

МХБХ-ны Зөвлөлийн 2023 оны 05 сарын 03 ны
өдрийн хурлын 25. тоот тогтоолоор батлав.



**МОНГОЛЫН ХӨЛБӨМБӨГИЙН ХОЛБООНЫ
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН БОЛОН ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ,
БҮРТГЭХ ЖУРАМ**
/нэмэлт, өөрчлөлт/

I. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1-р зүйл. Зорилго

- 1.1 Энэхүү журмын зорилго нь МХБХ-ны Гишүүдэд тавигдах шаардлагыг тодорхойлох, шаардлага хангасан хуулийн этгээдийг МХБХ-ны Их хурлын гишүүн болон Гишүүнээр элсүүлэх, бүртгэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2-р зүйл. Нэр томъёо

- 2.1 Энэхүү журамд хэрэглэсэн зарим нэр томъёо, нэр томъёоны товчлолыг дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

ОУХБХ- Олон Улсын Хөлбөмбөгийн Холбоо

АХБХ-Азийн Хөлбөмбөгийн Холбоо

МХБХ- Монголын Хөлбөмбөгийн Холбоо

Их хурал- Холбооны эрх барих дээд байгууллага

Зөвлөл- Холбооны стратеги ба бодлого тодорхойлох байгууллага

Их хурлын гишүүн- Их хурлаас Холбооны гишүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн хуулийн этгээд болон их хурлын гишүүн байна.

Гишүүн- МХБХ ба /эсвэл МХБХ-ны Их хурлаас гишүүнээр хүлээн зөвшөөрөгдсөн, Их хуралд санал өгөх эрхгүй хөлбөмбөгийн оролцогч /хуулийн этгээд/

Орон нутгийн хөлбөмбөгийн холбоо- Холбоонд захирагдах байгууллага

Клуб- ОУХБХ-ны гишүүн Холбооны гишүүн эсвэл Холбооноос хүлээн зөвшөөрсөн Лигийн тэмцээнд нэгээс дээш баг нь оролцдог гишүүн¹

Клуб лицензжүүлэх журам- МХБХ-ны Клуб лицензжүүлэх журам /MFF CLR/ гэдэг нь МХБХ-ны клубүүдийн хэрэгжүүлэх клуб лицензжүүлэлтэд тавигдах хамгийн бага шаардлагуудыг нэгтгэсэн ажлын анхан шатны бичиг баримтыг хэлнэ.²

Бусад - Энэхүү журамд тусгагдаагүй нэр томъёог МХБХ-ны Дүрэмд зааснаар ойлгоно.

II. ИХ ХУРЛЫН ГИШҮҮН БОЛОН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3-р зүйл. Их хурлын гишүүн болон Гишүүнд тавигдах шаардлага

- 3.1 МХБХ-ны Их хурлын гишүүн болон Гишүүнээр элсэх хүсэлт гаргасан этгээд нь өөрийн үйл ажиллагааны хүрээ, чиглэлээс хамаарч дараах ерөнхий шаардлагыг хангасан байна. Үүнд:

¹ МХБХ-ны дүрэм. 2023., 4 дэх тал

² Клуб лицензжүүлэх журам. 2020., 13 дахь тал

3.1.1 Орон нутгийн хөлбөмбөгийн холбоонд тавигдах ерөнхий шаардлага:

- А. МХБХ-ноос баталсан Орон нутгийн гишүүн холбоодын жишиг дүрмийг удирдах дээд байгууллагаараа баталж, түүний дагуу үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллага байх бөгөөд Улсын бүртгэлийн гэрчилгээтэй хуулийн этгээд байна.
- Б. Нарийн бичгийн даргаараа дамжуулан МХБХ-той байнгын харилцаа холбоотой ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- В. МХБХ-ноос баталсан загварт нийцсэн тамга, туг, бэлэг тэмдэгтэй байна.
- Г. Албан ёсны тодорхой хаяг бүхий ажлын байранд үйл ажиллагаа явуулахаас гадна банкинд өөрийн байгууллагын албан ёсны харилцах данстай байна.

3.1.2 Клубт тавигдах ерөнхий шаардлага:

- А. Удирдах зөвлөлийн гишүүд нь ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг өөр клубт аливаа хэлбэрээр давхар харьяалагддаггүй байна.
- Б. Сүүлийн хоёр жилийн хугацаанд жилд 2-оос доошгүй удаа МХБХ-оос зохион байгуулагдсан тэмцээн уралдаанд оролцсон байна.
- В. МХБХ-ны Клуб лицензжүүлэх журамд заасан шаардлагыг хангасан байна.

3.1.3 Шүүгчдийн зөвлөл, Дасгалжуулагчдын зөвлөл, Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл, Мастер ангиллын тамирчдын зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөлүүдэд тавигдах ерөнхий шаардлага:

- А. Албан ёсны гишүүнчлэлтэй, гишүүнчлэлийг баталгаажуулсан албан ёсны бүртгэлтэй байна.
- Б. Тус зөвлөлийн даргаар дамжуулан МХБХ-ны ЕНБД-тай харилцаа холбоотой ажиллах нөхцлийг бүрдүүлсэн байна.

3.2 Шүүгчдийн зөвлөл, Дасгалжуулагчдын зөвлөл, Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөл, Мастер ангиллын тамирчдын зөвлөлүүдэд тавигдах тусгай шаардлага:

3.2.1. Шүүгчдийн зөвлөлд тавигдах тусгай шаардлага:

- А. Шүүгчийн зөвлөлийн гишүүд нь МХБХ-ноос зохион байгуулсан шүүгчийн сургалтад хамрагдаж тэнцсэн, тангараг өргөсөн, МХБХ-ны ба ~~түүнээс дээш~~ Олон улсын зэрэглэлтэй шүүгч нар байна.
- Б. Тус зөвлөлийн гишүүн нь сүүлийн 2 жилийн хугацаанд МХБХ-ноос зохион байгуулсан 1-ээс доошгүй уралдаан тэмцээнд шүүгчээр тогтмол ажилласан байна.

3.2.2. Дасгалжуулагчдын зөвлөлд тавигдах тусгай шаардлага:

- А. Дасгалжуулагчдын зөвлөлийн гишүүд нь МХБХ-ноос зохион байгуулсан дасгалжуулагчийн сургалтад хамрагдаж тэнцсэн, лицензтэй, ОУХБХ, АХБХ, МХБХ-ны зэрэглэлтэй дасгалжуулагч нар байна.

3.2.3. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөлд тавигдах тусгай шаардлага:

- А. Эмэгтэй хөлбөмбөгийн зөвлөлийн гишүүд нь хөлбөмбөгийн спортоор хичээллэдэг, эмэгтэйчүүдийн хөлбөмбөгийг хөгжүүлэх үйл хэрэгт хувь нэмрээ оруулж буй зүтгэлтэн хувь хүн байна.

3.2.4. Мастер ангиллын тамирчдын зөвлөлд тавигдах тусгай шаардлага:

- А. Мастер ангиллын тамирчдын зөвлөлийн гишүүд нь Монгол Улсын хөлбөмбөгийн спортын-дэд мастер зэрэгтэй болон түүнээс дээш зэрэгтэй, Монгол Улсын шигшээ багийн гишүүн байсан эсвэл Үндэсний лигийн багийн тамирчин байсан, 37-оос дээш насны хувь хүн байна.

3.2.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөлбөмбөгийн зөвлөлд тавигдах тусгай шаардлага:

- А. Монголын Тусгай Олимпын Хорооны төлөөллөөс бүрдсэн зөвлөлийг хэлэх бөгөөд өөрийн дүрмийн дагуу төлөөллөө сонгоно.

- 3.3 МХБХ-ны Их хурлын гишүүнээр нэгэнт элссэн Их хурлын гишүүдэд энэ журмын 3.1 болон 3.2-дугаар зүйлд заасан шаардлага мөн адил үйлчилнэ.

III. ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, БҮРТГЭХ

4-р зүйл. Гишүүнээр элсэх хүсэлт гаргах

- 4.1 МХБХ-ны Гишүүнээр элсэх хүсэлтэй хуулийн этгээд нь Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын газарт албан хүсэлт болон МХБХ-ны дүрмийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зайлшгүй дагалдах баримт бичиг болон энэхүү журмын 3 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан тухай нотлох баримтын хамт ирүүлнэ.
- 4.2 Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Гишүүнээр элсэх хүсэлтийг хүлээн авч, түүний бүрдүүлбэр МХБХ-ны дүрэм болон энэ журамд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгана.
- Бүрдүүлбэрийн баримт бичиг дутуу байх тохиолдолд өргөдөл гаргагчид нэн даруй буцаана. Хүсэлт гаргагч нь Ерөнхий нарийн бичгийн газраас тавьсан шаардлагын дагуу дутуу бичиг баримтыг нөхөн бүрдүүлж, өргөдлийг дахин гаргаж болно.
- 4.3 Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь МХБХ-ны дүрэм болон энэхүү журамд заасан бүрдүүлбэр хангасан хүсэлтийг МХБХ-ны Зөвлөлд танилцуулна.
- 4.4 МХБХ-ны Зөвлөл нь Гишүүнээр элсэх хүсэлт болон бүрдүүлбэр баримт бичгийн үнэн зөвийг нягтлан шалгаж, Гишүүнээр элсүүлэх эсэх асуудлыг Их хуралд санал болгосноор Их хурал шийдвэрлэнэ. Хүсэлт гаргагч нь Гишүүнээр элсэх болсон шалтгаанаа Их хуралд мэдүүлнэ.
- 4.5 МХБХ-ны Их хурал нь Зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн гишүүнээр элсүүлэх эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

5-р зүйл. Гишүүнийг бүртгэх

- 5.1 Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Их хурлын шийдвэрийг үндэслэж, Гишүүнээр элссэн этгээдэд МХБХ-ны Гишүүний батламж олгоно.
- 5.2 МХБХ-ны Гишүүдийн бүртгэлийг Гишүүн байгууллагуудын менежментийн хэлтэс хариуцан хөтлөх бөгөөд гишүүдийн нэгдсэн мэдээллийн сантай байна.
- 5.3 МХБХ-ны Гишүүн байгууллагуудын менежментийн хэлтэс нь шинээр элссэн гишүүний мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, холбогдох материалыг архивлан хадгалах үүрэгтэй.

IV. ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР ЭЛСҮҮЛЭХ, БҮРТГЭХ

6-р зүйл. Их хурлын гишүүнээр элсүүлэх

- 6.1 МХБХ-ны Дүрмийн 12 дугаар зүйлд заасан Их хурлын гишүүн чөлөөлөгдсөн тохиолдолд МХБХ-ны дүрэм болон энэ журамд заасан шаардлага хангаж, хүсэлт ирүүлсэн гишүүнийг Их хурлын гишүүнээр элсүүлнэ.
- 6.2 Гишүүн клубийг Их хурлын гишүүнээр элсүүлэхэд Клуб лицензжүүлэлтийн шаардлага хангасан байдал, шалгуур үзүүлэлтийн эрэмбийг үндэслэнэ.
- 6.2 Их хурлын гишүүнээр элсэх хүсэлтийг Ерөнхий нарийн бичгийн даргын газар хүлээн авна.
- 6.3 Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь хүсэлт гаргасан гишүүний МХБХ-ны дүрэм болон Клуб лицензжүүлэлтийн шаардлага хангасан байдлыг шалгаж, МХБХ-ны Зөвлөлд танилцуулна.
- 6.4 МХБХ-ны Зөвлөл нь Их хурлын гишүүнээр элсэх хүсэлт болон холбогдох баримт бичгийг шалгаж, Их хурлын гишүүнээр элсүүлэх эсэх асуудлыг Их хуралд санал болгосноор Их хурал эцэслэн шийдвэрлэнэ. Хүсэлт гаргагч нь Их хурлын гишүүнээр элсэх болсон шалтгаанаа Их хуралд мэдүүлнэ.
- 6.5 Их хурал Гишүүнийг Их хурлын гишүүнээр баталсан үеэс эхлэн МХБХ-ны Дүрмийн 15, 16 дугаар зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

7-р зүйл. Их хурлын гишүүнийг бүртгэх

- 7.1 Ерөнхий нарийн бичгийн даргын газар нь Их хурлын шийдвэрийг үндэслэж, Их хурлын гишүүнээр элссэн этгээдэд МХБХ-ны Их хурлын гишүүний батламжийг олгоно.
- 7.2 МХБХ-ны Их хурлын гишүүдийн бүртгэлийг Гишүүн байгууллагуудын менежментийн хэлтэс хариуцан хөтлөх бөгөөд гишүүдийн нэгдсэн мэдээллийн сантай байна.
- 7.3 Гишүүн байгууллагуудын менежментийн хэлтэс нь шинээр элссэн Их хурлын гишүүний мэдээллийг нэгдсэн мэдээллийн санд оруулж, холбогдох материалыг архивлан хадгалах үүрэгтэй.

IV. ИХ ХУРЛЫН ГИШҮҮН БОЛОН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

6 дугаар зүйл. Их хурлын гишүүн болон Гишүүний эрх

- 6.1 МХБХ-ны Гишүүн нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:
- А. МХБХ-ноос зохион байгуулах төрөл бүрийн уулзалт, сургалт хэлэлцүүлэг, бусад үйл ажиллагаанд хамрагдах,
 - Б. МХБХ-ны дэмжлэгтэйгээр дотооддоо сургалт зохион байгуулах,
 - В. Өөрийн зохион байгуулж буй үйл ажиллагааны хүрээнд МХБХ-оос зохих дэмжлэг авах,
 - Г. МХБХ-ны лого тэмдэг ашиглах.
 - Д. МХБХ-оос зохион байгуулж байгаа Олон улсын болон Дотоодын уралдаан тэмцээнд оролцох,
 - Е. ОУХБХ болон АХБХ-ны нэгдсэн бодлого, дэвшүүлж буй зорилго, хөлбөмбөгийн спортын цаашдын чиг хандлага, МХБХ-ны зүгээс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн талаарх шаардлагатай мэдээлэл авах,
- 6.2 МХБХ-ны Их хурлын гишүүн нь энэхүү журмын 6.1-р зүйл болон МХБХ-ны дүрмийн 15-р зүйлд заасан гишүүний эрхийг эдэлнэ.

7 дугаар зүйл. Гишүүний үүрэг

- 7.1 Гишүүн нь МХБХ-ны дүрмийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалтад зааснаас бусад үүргийг чанд биелүүлнэ.

8 дугаар зүйл. Гишүүнд хориглох зүйл

- 8.1 МХБХ-ны Гишүүн байгууллагын гишүүн нь МХБХ-ны бусад гишүүн байгууллагад давхар харъяалагдахыг хориглоно.

V. БУСАД

9-р зүйл. Бусад зүйл

- 9.1. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс чөлөөлөх, татгалзах асуудлыг МХБХ-ны дүрмийн 17, 18, 19 дүгээр зүйл нэгэн адил хамаарна.
- 9.2. Энэхүү журмын зүйл заалт нь МХБХ-ны дүрмийн зүйл заалттай утга агуулгын хувьд зөрүүтэй тохиолдол бий болсон тохиолдолд МХБХ-ны дүрмийн заалт нь давуу хүчинтэй байна.
- 9.3. МХБХ-ны Удирдах зөвлөл нь МХБХ-ны дүрэм журамд нийцүүлэн энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.